

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД,  
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

124

2007 оны 12 дугаар сарын 19-ны өдөр

Дугаар 136 / 57

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн атташегийн ажиллах журам батлах тухай

Монгол Улсын БНСУ-д суугаа ЭСЯ-нд Хөдөлмөрийн атташе ажиллах болсонтой холбогдуулан ТУШААХ НЬ:

1. Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Хөдөлмөрийн атташегийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Хөдөлмөрийн атташегийн ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэхийг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Бэхбат, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга О.Байгалмаа нарт даалгасугай.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН  
САЙД  
Д.ДЭМБЭРЭЛ

ГАДААД ХӨРГИЙН  
САЙД  
С.ОЮУН

НХХ-ийн сайд, ГХ-ийн сайдын  
2007 оны 06 15 дугаар хамтарсан  
тушаалын хавсралт

**МОНГОЛ УЛСААС БНСУ-Д СУУГАА ЭСЯ-НЫ  
ХӨДӨЛМӨРИЙН АТТАШЕГИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Хөдөлмөрийн атташе /Цаашид “хөдөлмөрийн атташе” гэх/ нь БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа Монгол иргэдийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудлыг хоёр орны холбогдох хууль тогтоомж, байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн дагуу зохицуулах, ажиллах хүч хүлээн авах, илгээх байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, иргэдийн хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалал авах эрхийг баталгаажуулах үүрэг гүйцэтгэнэ.

2. Хөдөлмөрийн атташег Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны саналыг үндэслэн Гадаад хэргийн яам томилно.

3. Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны хоёр хөдөлмөрийн атташе ажиллах бөгөөд БНСУ-д ажиллах хүч илгээх бодлогын хэрэгжилт болон БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудлын зохицуулалтыг хариуцна. Бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан хөдөлмөрийн атташе нь ахалж ажиллана.

**Хоёр. Хөдөлмөрийн атташегийн ажил үүргийн хуваарь**

**БНСУ-д ажиллах хүч илгээх бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан хөдөлмөрийн атташе нь:**

1. Хоёр орны Засгийн газар хоорондын хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтийг хангах, цаашид харилцааг гүнзгийрүүлэх чиглэлээр санал, баримт бичиг боловсруулах;

2. Монгол Улсын “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”, БНСУ-ын Гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, түүний хүрээнд хоёр Засгийн газар харилцан тохиролцсон Санамж бичиг, бусад эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

3. Монгол Улсаас БНСУ-д ажиллах хүч илгээхэд баримтлах Засгийн газрын бодлого чиглэл, энэ талаар авах арга хэмжээний талаар санал дэвшүүлэх, Монгол Улсаас оруулах ажилчдын зөвшөөрөл, квотыг БНСУ-ын Засгийн газраар гаргуулах талаар суугаа орны холбогдох байгууллагуудтай

хамтарч ажиллах, олгогдсон квотыг үр дүнтэй ашиглах арга хэмжээ авахуулах;

4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хамтын ажиллагааны эрх зүйн орчинг бататгах, шинэчлэх буюу шинээр байгуулах шаардлагатай эрх зүйн баримт бичгийн талаар судалгаа хийж санал боловсруулах.

5. БНСУ-ын Засгийн газраас ажиллах хүчний талаарх баримталж байгаа бодлого, хууль эрх зүйн талаар мэдээллээр хангаж ажиллах

6. Одоогийн мөрдөж байгаа журам /бүртгэлийн, Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын гэх мэт/ болон эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар БНСУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

**БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын зохицуулалтын асуудал хариуцсан хөдөлмөрийн атташе нь:**

1. Монгол Улсаас БНСУ-д ажиллах хүчнийг илгээх, хүлээн авах, сургалтад хамруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, үйлдвэрүүдэд хуваарилах зэрэг асуудлаар суугаа орны Хөдөлмөрийн яам, түүний харъяа албад, БНСУ-ын Олон Улсын Хөдөлмөрийн сан зэрэг бусад холбогдох байгууллагатай нягт хамтран ажиллах;

2. БНСУ-д ажиллах хүч илгээгч байгууллагуудын төлөөлөгчийн газруудтай хамтран ажиллах, шуурхай удирдлагаар хангах;

3. Монгол ажиллагчдын цалин хөлс, нэмэгдэл ба нэмэгдэл хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, нөхөн олговор зэрэг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны асуудлыг зохицуулах, иргэдэд зөвлөгөө өгөх;

4. БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг үйлдвэрлэлийн болон ахуйн осол, өвчлөл, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааг илгээгч байгууллагын төлөөлөгчийн газруудтай хамтран явуулах, осол өвчлөл, гэмт хэрэг гарсан тохиолдолд тэдгээрийн мөрөөр шуурхай арга хэмжээ авах, БНСУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-ны Консулын хэлтэс, илгээгч байгууллага, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

5. БНСУ-д ажиллаж байгаа болон шинээр ирж байгаа ажилчдын мэдээлэл, ажиллаж байгаа үйлдвэрийн газруудын хаяг, тэдний цалин хөлс, хөдөлмөрийн харилцаа, ажил мэргэжлийн чиглэл, нийгмийн хамгааллын асуудлаар улирал бүр судалгаа гаргаж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, ЭСЯ зэрэг бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн сүлжээ байгуулах;

6. Монгол ажилчдын болон БНСУ-ын үйлдвэрийн газрын эздийн санал хүсэлтийг сонсож, тэдгээрийг хоёр орны хооронд байгуулсан хамтын

ажиллагааны гэрээ, хэлэлцээр болон үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход тусгах талаар санал боловсруулж, төвд илгээх.

7. Солонгосын талын байгууллагууд, ажил олгогч нарт Монгол Улс, монгол ажилчдыг сурталчлах арга хэмжээ холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах үүрэг гүйцэтгэнэ.

#### **Гурав. Ажлын төлөвлөгөө, үр дүнгийн тайланг хэлэлцэх**

1. Хөдөлмөрийн атташе нь тухайн жилийн ажлын төлөвлөгөөгөө Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай урьдчилан зөвшилцөж, Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдаар батлуулан мөрдөж ажиллана.

2. Тухайн жилийн ажлын тайлангаа Элчин сайдаар хянуулж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд хүргүүлж байна.

3. Өдөр тутмын ажлаа БНСУ-д суугаа Элчин сайдад тайлагнаж, чиглэл авч ажиллана.

-----ОоО-----